



ХЭНГИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/24

Мөрөн сум

“Зөөврийн сууц” хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2026 оны 03 сарын 16-ний өдрийн А/52 тоот захирамжаар байгуулагдсан Сумын ажлын хэсгийн 2026 оны 03 сарын 16-ний өдрийн 01 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. “ТҮМЭН БОГЦ”-ХХК нь сумын Эрсдэлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Зөөврийн сууц”- хийх ажлын сонгон шалгаруулалтад тэнцэж 2026 оны 03 сарын 16-наас 2026 оны 04 сарын 16 -ний дотор хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан тул уг ажлын явцад захиалагчийн зүгээс хөндлөнгийн хяналт байнга тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авах эрх бүхий сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:	Т.Баяртуяа	ИТХ, ЗДТГ хариуцсан нягтлан бодогч
Гишүүдэд:	Г.Хишигбаатар	Хууль, эрх зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн /БӨХБЗ гишүүн/
	А.Энхтөр	Аж ахуйн нярав

2. “ТҮМЭН БОГЦ” ХХК-аас хүлээн авах “Зөөврийн сууц”-ыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн өнгө үзэмж, тоо ширхэг, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (Т.Баяртуяа)-д үүрэг болгосугай.

3. “Зөөврийн сууц”-ны цаашдын хадгалалт хамгаалалт, ашиглалтад байнгын хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж ажиллахыг Тамгын газрын аж ахуйн нярав (А.Энхтөр)-д үүрэг болгосугай.

4. "Зөөврийн сууц"-ыг Засаг даргын Тамгын газрын хөрөнгөнд бүртгэж авч ажиллахыг нягтлан бодогч (Т.Баяртуяа), Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Ц.Болорцэцэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ